

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/127/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2022 он	Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч: Ш.Мөнхбаяр Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Ахлах аудитор: Х.Сувдмаа Утас: 70373089 Цахим хаяг: Suvdmaakh@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

47000 Дархан-Уул аймаг
Дархан сум, 14-р баг
Утас 7037-3080, Факс 7037-3089
E-mail darhanuul@audit.gov.mn

ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Х.ОЮУНЦЭЦЭГ ТАНАА

2022.02.11

№ 66

Тайлбар

Холбоо

Холбоо

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

01

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг захиран эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага захиран эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь захиран эсвэл алданаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭВЧ

Ш.МӨНХБАЯР



009070047

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	86,903,232.99	81,573,641.38
	Мөнгөн хөрөнгө		13,448,850.00
	Авлага		-
	Бараа материал	86,903,232.99	68,124,791.38
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,288,272,401.50	1,227,263,105.39
	Нийт хөрөнгийн дүн	1,375,175,634.49	1,308,836,746.77
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,375,175,634.49	1,308,836,746.77
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,375,175,634.49	1,308,836,746.77
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,118,758,687.79	1,107,725,950.00
	Үйл ажиллагааны зардлын дүн	962,689,956.01	1,155,633,862.57
	Үйл ажиллагааны үр дүн	156,068,731.78	(47,907,912.57)
	Үнэ төлбөргүй гарсан зардал	4,230,075.00	18,430,975.15
	Үйл ажиллагааны бус үр дүн	(4,230,075.00)	(18,430,975.15)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	151,83,656.78	(66,338,887.72)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	820,279,777.00	1,375,175,634.49
	Тайлант оны үр дүн	-	(66,338,887.72)
	Эцсийн үлдэгдэл	820,279,777.00	1,308,836,746.77
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	905,755,011.00	1,081,351,450.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	895,307,611.00	1,044,552,600.00
	Үйл ажиллагааны ЦМГ	6,609,000.00	36,798,850.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(6,609,000.00)	(23,350,000.00)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	13,448,850.00
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,023,842,600.00	987,529,979.07
	Урсгал зардал	1,023,842,600.00	987,529,979.07
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,023,842,600.00	987,529,979.07
	Улсын төсвөөс санхүүжих	1,023,842,600.00	987,529,979.07

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Татварын хэлтэс нь татвар төлөгч хуулиар хүлээсэн татвар төлөх үүргээ, эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж, хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилготойгоор 5 зорилт 54 чиг үүргийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн 6 дугаар зүйлд заасантай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 143,480.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд санхүүгийн тайланд 13,448.8 мянган төгрөгийг залруулж, 1,176.1 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 128,855.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Мөнгөн гүйлгээний тайланд 13,448.8 мянган төгрөгийн бусад орлогыг дутуу тайлагнасныг залруулав.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 1,176.1 мянган төгрөгийн илүү олгосон цалин, албан томилолтын зөрчлийг аудитын явцад барагдуулав.

4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх асуудал гараагүй болно.

4.4 Зөвлөмж

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

1.1 Илрүүлэлт:

Тайлант оны 4. 6 дугаар сард нийт 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, төсөв, хөрөнгө зарцуулахтай холбоотой 128,855.4 мянган төгрөгийн 6 тушаалыг мэдээлээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийг мөрдөн ажиллаж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

(сая төгрөгөөр)

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	4	14.7	1	13.5	3	1.2				
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	4	14.7	1	13.5	3	1.2				
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ	1	128.8							1	128.8
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	1	128.8							1	128.8
	НИЙТ ДҮН	5	143.5	1	13.5	3	1.2			1	128.8